



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/25

Хэрлэнбаян-Улаан тосгон

Зардал гаргах тухай

Монгол Улсын "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 17 дугаар зүйлийн 17.3, "Төсвийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх гудамж талбайд цамхаг гэрэлтүүлэг, камер суурилуулах ажилд 17,000,000 (Арван долоон сая) төгрөг зарцуулсугай.

2. Гудамж талбайд цамхаг гэрэлтүүлэг, камер суурилуулах ажилд зарцуулагдах 17,000,000 (Арван долоон сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ

